

ХЭЛ, ХИЛ ХОЁРЫНХОО ХЭЛХЭЭГ ТАСЛАХГҮЙ ЮМСАН



2000 оны "Утгын чимэг" богино өгцүллэгийн наадамд "Марал гоогийн дуудлага" өгцүллэгээрээ тэргүүн байр эзэлсэн МЗЭ-ийн шагналт зохиолч Дамбадаржаагийн Намсрайтай Г.Дагважамцын хийсэн ярилцлагыг уншигч танд толилуулж байна.

ГД: -Та эх орны хил хязгаар, хилчдийнхээ тухай зохиол бүтээл түүрвдэг цөөхөн зохиолчдын нэг. Таныг Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгт (МХСҮН) гишүүнээр элсэх гэж байгаа тухай сонслоо. Энэнээс яриагаа эхлэх үү?

ДН: -Дархан хилээ судлах гэсэн дайчин нөхөдтэйгээ ойр дотно явж, чадах чинээгээрээ туслахыг хүсэлгүй яахав. Энэ бол эх орны иргэн бүрийн үүрэг гэж боддогоос элссэхээр шийдсэн.

ГД: -Зохиолч Д.Намсрай монголын төдийгүй гадаадын олон орны уншигчдын танил. Таны хувьд эх оронч үзлийн төлөвшил хэдийнээс төлөвшин тогтож эхэлсэн бэ?

ДН: -Бага сургуульд байх хүүхэд ахуй наснаасаа зураг, уран зохиол сонирхдог байлаа. Монголын газрын зургийг зурах хичнээн сонирхолтой байсан нь юуны учир юм бүү мэд. Эх орон монгол нутаг гэдгийг л элэг зүрхэнд минь шингээхийг хичээсэн багш нарын минь буян заяа, холын ухаан байсан биз ээ. "Шивээ хиагт"-ийг дуулуулж, Д.Нацагдоржийн "Миний нутаг"-ийг цээжлүүлж сурган ухааруулсан нь учир утгын эхлэл байжээ дээ.

ГД: -Ц.Уламбаяр гуйн "Энхтайвны манаа", таны "Тооройн төгөл" хоёроос өөр хилийн цэргийн тухай томоохон зохиол бүтээл тун ховор байдаг. Хилийн амьдралаар амьдарч, хилчний тогоотойг хуваалцаж яваагүй та яаж ийм сайхан зохиол бичсэнийг сонирхвол?

ДН: -Олон жилийн өмнө хилийн цэргийн ойд зориулсан өгүүллэгийн

уралдаанд тэргүүн байр эзэлж, бас "Утгын чимэг"-ийн наадамд "Хил, хэл хоёр минь" богино өгүүллэгээрээ аман хүзүүдэн, хожим "Тооройн төгөл" туужаа бичиж олон уншигчидтайгаа сэтгэлээ хуваалцсан юм. Москвад байхдаа, академид суралцаж байсан багын нөхөр, ангийн найз ХЦ-ийн ахмад Даваахүүгийн Нямдоржтой хил хязгаарт тохиолдсон, уншиж судалсан үйл явдлуудын талаар хуучлан сууснаа бодит байдлаас санаа төрж "Тооройн төгөл"-ийг бичсэн юм.

ГД: -Та бас "Тооройн төгөл"-өө жүжиг болгож тавьсан гэл үү?

ДН: -Ажил мэрэгжил, албан үүрэгтээ үнэн халуун сэтгэлтэй хэдэн нөхөд бодол урмыг минь бадрааж, Багануур дахь ХЦ-ийн ангийнхны хүчийг ашиглан (мөнөөх Д.Нямдорж ангийн захирагч байхад) "Тооройн төгөл" туужаа жүжиг болгож тавьсан. . . . Уул нь хилийн олон анги, салбар, хязгаарын аймаг, сумдаар тоглолт хийж тойрсон бол сайхан л байхаар санагдсан. Цаг, түүхийн салхи таалаагүй тэгэхийгээд өнгөрсөн

Харин завшаан тохиосных хэлэхэд "Энэ яваа насандаа "Тооройн төгөл"-өөр л заавал кино хийж, өөрөө би гол дүрийг нь бүтээнэ" гэж чин сэтгэлээсээ хүсэн, олон жил мөрөөдөж яваа манай нэртэй найруулагчийн нэг Сэлэнгэсүрэн ийм боломжийн эрэлд хатан, одоо ч үүнийг л кино болгохсон гэж ярьсаар явна билээ.

ГД: -Цаашдаа нийгэмлэгтэйгээ, ХЦ-тэйгээ уран бүтээлийн ямар холбоо тогтоож, яаж ажиллая гэж бодож байна даа?

ДН: -Сэтгүүлчийнхээ үүргийг гүйцэтгэж бодит ахуй амьдралыг судлан сурвалжлахсан. Түмэн олон ард минь мэдэж ойлгож ухаарч яваасай гэж бодолгүй яахав. Нийгэмлэгийг санаачилсан мэргэд ухаантнуудад санаашран эмзэглэсэн олон бодол төрсөн нь гарцаагүй. Үг үзэг хоёр минь өчүүхэн ч болов тус хүргэж чадвал, хэл, хил хоёрынхоо хэлхээг таслахгүй юмсан гэж санадаг аа. Унах морь нисэх далавчгүй надад тус хүргэвэл та нартайгаа явахыг хүснэ. Гүрэн улсынхаа хил хязгаарыг төдийгүй орон байр, өрх гэртээ хэм боловч хаяа хатавч, хаалга үүдээ л хамгийн түрүүнд гэдэг шүү дээ.

Энэ нийгмийн хийгээд эх орныхоо хил хязгаарын төлөө иргэн бүрийн бодол ухаан саруул байж, өөдрөг шинэ санаачилга, төр засгийн түмэн мэлмий хурц болтугай гэж ерөөе.

МАРАЛ ГООГИЙН ДУУДЛАГА

Намрын дунд сар. Жар гарсан өвгөн Молом модон тэргэнд гунан бухаа хөллөжээ. Ар газраан ирж пүнзээ ухан жижиг бор гэрийнхээ хөвөнтэй дээвэр туурга, бага сага борц гурилаа тэргэн дээрээ тавиад намаржааны зүг хөдөллөө. Эрт сэрүү унаж дан бүрээстэй умгар бор гэр нь өглөө үдшээр даарах янзтай тул ийнхүү амь амьдралаа татаж яваа нь энэ. Охин хүү хоёр нь аль эрт нийслэл хотдоо суурьшиж айл гэр болцгоосон. Хүү нь Солонгос орон руу явсан сурагтай. Охин нь хотод ирээч гэж хэл дуулгавч, талийгч ханийхаа ясыг тавьсан газарт сэтгэл хоргодон төрсөн нутгаасаа явах өвгөн биеэ өөрөө жолоодохоос өөр яана гэхэв. Сүүлийн таван жил гон биеэрээ амиан борлуулж явахад хүүхдүүдээс нь гурван жилд хэн нь ч эргэж ирээгүй явдал голыг нь харлуулна.

Яарч сандарсан ч юмгүй халиу ягаан бухаа хөтлөн Вандуйн давааны хадтай чулуун зам, унанги мод, үерт эвдэрсэн жалга судаг, бартаа сувгаар нь хэг ёг, дэр дар хийлгэсээр даваагаа даван уруудаж явахад нь нар жаргалаа. Замдаа хэд гурван гишүү түлээ дайж авахаар хажуухан талын зураа мод руу оржээ. Насаараа шахам үүрч явдаг хуучин бирдаах буунаасаа одоо ч салалгүй мөрөндөө эгэлдэргэлж яваа янхир хөх өвгөний хөл, бух тэрэгний гишгэлтэнд харьж яваа цагийн гандаж шарласан навчис, хунгар цас нажигнан шужигнана. Тэгтэл хожуул дайрсан тэрэгнийн гол тархийн хугарлаа. "Еэ лүд, еэ лүд . . ." гэж Молом амандаа үглэн буугаа мод түшүүлж бухаа буулганаас мултлан холхон ширэнгэнээс уялаа. Тэрэгнийхээ голыг үзэхэд олон жил эргэлдэж элэгдсэн мод өөрийнх нь гарын шуу шиг нарийсчээ. "За яахав, яршиг цаашаа. . . Эндээ хоноод өглөө ноцолдохоос биш" гэж шийдсэн Молом ачаагаа задлан дээвэр туургаа буулган дэвсгэр хучлага засав. Мод толгойгоо нэрж уугиулан суухад унд хоолондоо хүрсэн шиг санаа нь тайвширна.

Хэдэн малаа айлд байлгаж, гэр оронд нь хүлээх хүнгүй болохоор яарах даарах ч юмгүй өвгөн яана гэхэв, хажуулдан хөвтлээ. Энэ зуур нойр нь хулжиж, бэлийн горхи хоржигнон шуугиж, намрын салхи модны оройгоор нэгийг шивнэн сэргчигнэнэ. Одтой тэнгэр, тэртээ уулын хярыг харан хөлбөрч буй өвгөний цээжинд бодол хөвөрнө.

Дөчин жилийн тэртээ яг л энэ уулын аманд малаа хариулсан Дэлгэрмаатайгаа учран болзож, гүзээлзгэнэ жимс амтлан эрхлүүлэн наадаж явсан сан. Модны сүүдэр, өвс, ногоо өнгийн цэцэгсийн дунд

өлгий дундаа энхрийлэлдсэн нялх багахан хүүхдүүд шиг аз жаргалын дээдийг эдэлж явсан нь өвгөний цээжнээ өчигдөрхөн юм шиг санагдана.

Энэ шөнө ид нойрон дунд нь гандаж шарласан навчсын чимээ шажигнан ямар нэгэн хөнгөн гишгэгдэлтэй, тураг амьтны туруу аргайн нужигналт илэрхий сонсдов. Молом толгойгоо ялимгүй өндийлгөж нүд нуухаа арчин ажиглалаа. Тал сарны туяанд нэгэн амьтан хэдхэн алхмын цаана тулж ирлээ. Сумтай буугаа алгуурхан барьж өндийлөө. Цав цагаан согоо чихээ солбилзуулан түрүүнээс хойш Моломыг хэд дахин тойрсон бололтой үнэрлэн шиншлэх мэт байн байн тонголзон сэрмэлзсээр ...

Согоо байна гэж танисан ч Моломын дотор сэртхийн домог түүхтэй холбоотой далдын бодол зурсхийв. "Энэ цав цагаан, цас цагаан цалин цагаан согоо жирийн амьтан биш байна.... Буутай буурлаас ч айлгүй сонортон сониучирхсан энэ амьтан ГОО МАРАЛЫН удам болж таарна. Энэ шидэт амьтан... Ээ бурхан минь намайг шохоорхдог нь юу билээ? Ээ тэнгэр минь, Бурхан буяны оронд очсон талийгчийн минь сүнс хэдэн арван жилийн өмнөх болзож уулздаг газартаа намайг байна гээд эргэж ирсэн юм биш биз. Араатан чононоос зугатсан ганцаардмал амьтан намайг бараадав уу...." Дотроо гүвтнэсэн Молом өндийн бослоо. Хамар самсаа нь тургилах мэт чимээ гарган толгойгоо сэгсэрсэн согоо ямар нэгийг ойлгуулж ядан байх шиг өвгөнд санагджээ. "Яв даа яв, гоо марал минь! Нүгэлтнүүдээс болгоомжил! Ясан эвэр, цусан эвэр, бугын чив, согоон сав ... гэдэг чөтгөрүүд хааяагүй бий... Чи минь Дэлгэрмаагийн сүнс мөн шиг байна....Намайг аваад яв. Эсвэл би араас чинь очно. Цаана чинь чоно байвал би зайлуулаад орхие..." гэж үглэсэн Молом бирдаах буугаа авч дээш харуулан тасхийлгэлээ. Тэнгэрийн луу, лусын дуу шиг их чимээ нүргэлэн мод хад, уул ойг цуурайтуулан нижигнэв. Галт шугам татуулсан нэгэн оч тэнгэртээн харвах шиг оддын зүг алслан жижгэрсээр алга боллоо. Цагаан согоо ч их зураа өөд эргэн эргэн харсаар дүүлэн одов.

Сүнс сүүдэрт итгэсэн Моломын бодол гүн хямралд оржээ. Тэгтэл тэр өглөөний үүр манхайтал цайсан цагаар юу болсон гэж санана. Өөрийн эрхгүй хэсэг дугхийгээд сэрсэн өвгөнийг өндийхөд ухаа ягаан бухны нь дэргэд мөнөөх цагаан согоо харагдлаа. Чухам энд юу болоод өнгөрснийг хэн ч үл мэднэ. Өглөөний манан уул бэлийг ороон хэлхэрч, тэртээх энгэрт малгайн чинээ үүлнээс түр зуурын бороо шаагиад өнгөрсөн юм. ..Моломын дөхөж явааг харсан согоо "Энэ чинь юу болов оо?" гэх шиг биеэ сэгсрэн эргэн тойрныг ажсанаа

бусдаас ичингүйрэн зугатаж нуугдах газрыг зорих мэт цахилан цамнан одов оо. . .

Даралт ихсэж зүрх нь дэлссэн өвгөн Моломын толгой эргэж, согтуу хүн шиг найган ганхлаа. Хөтлөх түүшингээ аль хэдийн тасалсан гунан бух ч эзнээ орхиод цүл цүлхийн шогшиж шүлсээ савируулан урамдсаар сүргийн зүг яаруухан явлаа.

Хэл нь дультран өрөөсөн дугуйгаа түшсэн өвгөн Молом "Марал гоо минь Дэлгэрмаа минь..." хэмээн шулганасаар. Түүний нүднээ мөнөөх л цагаан согоо тэнгэрт харагдаж урамдан дуудсаар байжээ...

Намаржааны айлууд ухаа ягаан бухы нь анзаарснаас хойш хэд хоног төдийлөн үгүйлсэнгүй гэдэг. Молом буюу "Ерөөл" хэмээх сайхан нэрээ жаран хэдэн жил дуудуулсан тэр хүн гэртээ иргэж ирээгүй юмаа.

Арван найман салаа эвэртэй хангал халиун буга болон хувилаад Маралгоогоо хайж тэнгэртээн ниссэн байлгүй хөөрхий...

1999. 2000 оны зааг

Д.ЦООДОЛ (Төрийн шагналт яруу найрагч)

ТУВАД БИЧСЭН ЗАХИДАЛ

*Сувдаг хорон санаатан цөл гаталж биш
Сураг холын дайсан далай туулж биш
Сүл, барьцгүй алсын харь гаригаас ч биш
Суувч босовч бараандаа айлын минь та нар
Сувдан цагаан гэрээд маань буудав, яах нь энэ вэ Тува
Дэрс цүргэлсэн Монголын цэнхэр тал
Дээдсийн чинь сүргийн зах хүрч бэлчсэн хязгаар!!
Голомтны маань чулуу тусдаа ч уул нь цуг билээ
Гохондоо хуруу чинь яаж хүрээ вэ Тува
Асар тэнгэрийн саран цуцаж хүрэх хаяа
Айлын гэрээр яривал хүчхэд тоглох хоймор
Амгалан Увсын мандалд шувууг нь битгий цргээ
Аргалын улаан гал, бүрханыг битгий цочоо!
Алдас болно дахиад бүү тэнэглэ Тува
Тавтиргүй муудаа биш, хүчтэнийг дагаад явчихаар нь
Танай Тогоог, Маршал өөрийнх нь төлөө алгадсан*

Танагаа барьж өнөөдөр нэрээ хорлож яваа
Танхай банди нарыг чинь би бүгдийг нь алгадмаар байна.
Шооч дэлхийн нүдэн дээр та нарын алдсан тоогоор
Шороон дор өвгөдийн минь яс зэрэг шархираа даа Тува
Хар-Оол, Цагаан-Оол, Сариг-Оол
Хаяа хилийн минь үүдийг хумсгүй болтлоо маажлаа
Харсаар үзсээр байж хүний өөрийнхийг ялгадаггүй
Хаашаа улс вэ танай энэ олон "Оол"
Хорвоогийн алган дээрээс од гариг руу мордож
Холын сарны шороог Орос авчраад удлаа
Хотонд орохоор мордож таны хөвгүүд өнөөдөр
Хонь авчирлаа гэе хэн магтах вэ Тува
Амь амьжиргаа тусдаа хэн нэгэнд туулгаснаас
Арав таван малаа би нутгийнхаа чононд идцүлмээр байна.
Өрөөлийн үүрнээс ульждаг хэрээ биш дээ ямар
Өндрөө авч бүргэд шиг үнэг шүүрээч Тува
Өөрийн нь төлөө үхэхээс айхгүй хүнд эх орон заяадаг
Өгөөмөртөө биш хулчгар нь эх орноо бусадтай хуваадаг
Суун тусаад босоогүй хилчин хүү минь байтугай
Сумны сорвитой чулуу эх орон юм шүү Тува
Сэргэр сэргэр уулс минь нүүцгээд хаа холдох вэ
Сэтгэлд минь битгий юм хий Тува

2000.03.13